

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Баасанбат* Б.БААСАНБАТ

Огноо: 2019 оны *08* дугаар сарын *21*-ний өдөр

ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨВ ТАЛБАЙГ ТОХИЖУУЛАХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ҮНИЙН
САНАЛ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Шивээговь сумын Төв талбайг тохижуулах ажлын
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Төслийн дугаар: ГСАШГСЗДТГ/201912003

Говьсүмбэр аймаг Шивээговь сум

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.08.21

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Сумын төв талбайг тохижуулах ажил”**ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

2019 оны 08 сарын 29-ний өдрийн 11 цагаас өмнө цахим тендерт ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 08 сарын 29-ний өдрийн 11 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх- Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг,
Нутгийн удирдлагын ордон, 2-р давхар, 208 тоот өрөө,
Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
З.Баасандалай, 99038561**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх 2. Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ туршлагын мэдээлэл, ижил төстэй ажлын талаарх мэдээлэл, тайлан /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, ажил хүлээлцсэн улсын комиссын акт ирүүлэх 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний наториатаар гэрчлүүлсэн байх; 4. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Хуучин: БУ-2.1.1. буюу Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт Шинэ: БА-8.1 буюу Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил 5. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон банкнаас авах боломжтой зээлийн хэмжээ тухайн тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30%-аас багагүй байх; 6. Ижил төстэй ажлын борлуулалтын хэмжээ нь /сүүлийн 1 жилийн орлогын хэмжээ /2018 он/ тухайн тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50%-аас багагүй байх/ 7. Татварын байгууллагын тодорхойлолт /өргүй эсэх, татвар төлсөн эсэх/ 8. Харилцагч банкуудын тодорхойлолт /хугацаа хэтэрсэн өр зээлгүй байх/ 9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 10. Нийгмийн даатгалын тодорхойлолт /байгууллага сүүлийн 1 жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх/ Ажиллаж буй ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн маягтыг хамт ирүүлэх-НД8 11. Тендерийн баримт бичгийн хуудас болгонд тамга дарж, дугаарлаж, гарын үсэг зурсан байх 12. Тендерт ирүүлэх албан бичиг, тодорхойлолтуудын хугацаа нь тендер зарлагдсанаас хойш байх; 13. Гэрээг гүйцэтгэхэд дараахь мэргэжилтэй ажилчид шаардлагатай бөгөөд инженерүүд нь үндсэн ажилтан байна. Мэргэжлийн инженер техникийн ажилчид нь тухайн мэргэжлийн чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай байх. /НД дэвтрийн хуулбар, нийгмийн даатгалын тооцооны хуудас, ажилд томилсон тушаал, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, дипломын хуулбарыг хавсаргана/. 14. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: а. Барилгын засвар, газар шороо, цахилгааны ажилд хэрэглэх тоног төхөөрөмж, бусад багаж, хэрэгсэлүүд 15.Тендерт оролцогч нь үнэлэгдсэн үе шатны хуваарийг баталгаажуулж ирүүлэх 16. Ажлын тоо хэмжээтэй уялдуулан тооцсон төсөвтэй байх /Мэргэшсэн төсөвчнөөр хийлгэсэн байх/ 17. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа тухай албан мэдэгдэл ирүүлэх 18. Шалгарсан тохиолдолд “Техникийн тодорхойлолт”-д тусгасан шаардлагуудыг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ. 19. Харьяалагдах банк, татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг ирүүлнэ. 20. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлэх

	21. Дээрх шаардсан мэдээллийн аль нэгийг ирүүлээгүй нь оролцогчийн саналаас татгалзах үндэслэл болно.
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг, Нутгийн удирдлагын ордон Огноо: 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Цаг: 11 цаг 00 минут Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Тендер хүлээн авах этгээд: Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн З.Баасандалай
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р баг, Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар, 203 тоот Огноо: 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Цаг: 11 цаг 30 минут
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Сумын төв талбайг тохижуулах ажил”-ГСАШГСЗДТГ/201912003

БАТЛАВ.
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *О. Доржпалма* БААСАНБАТ

2019 оны *08* дугаар сарын *22*-ны өдөр

ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨВ ТАЛБАЙГ ТӨХИЖУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 1-р баг “Сумын төв талбайг тохижуулах ажил”-д дараахь шаардлагуудыг бүрэн хангасан байна.

1. Ажилд тавигдах ерөнхий шаардлага

Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажиллах бөгөөд батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг чанд мөрдөн ажиллаж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж зарцуулах

- Гүйцэтгэгч нь зохиогч болон захиалагч, захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллах шаардлагатай.

- Ажлыг үе шат бүрт захиалагчийн хяналтын инженерт үзүүлж, фото зургаар баталгаажуулж, акт үйлдсэний дараа дараагийн ажлыг үргэлжлүүлэн хийх зөвшөөрлийг авч ажиллана.

- Ажилд хэрэглэгдэх материалуудыг барилгын талбай дээр их хэмжээгээр татахаасаа өмнө дээжийг захиалагчид үзүүлж, зөвшилцөх зарчим баримталж ажиллана. Захиалагчтай зөвшилцөөгүй, буруу буюу чанаргүй материал авчирч, ажилд ашиглах тохиолдолд түүнээс үүдэн гарах алдагдлаа гүйцэтгэгч хариуцна.

- Зайлшгүй шаардлагаар барилгын хийцлэл, материалыг өөрчлөх тохиолдолд захиалагчид албан тоотоор хандаж, зохиогч захиалагчаас бичгээр зөвшөөрлийг авч өөрчлөлтийг хийнэ.

- Ажлыг гүйцэтгэх үед дулаан болон холбоо, цахилгааны шугамын утас, газар доорх шугам хоолой, холбоо, цахилгааны утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.

- Оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хашаа хамгаалалтыг хийж, иргэдийн зорчих хэсгийг гаргаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнуудыг хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангана.

- Орон нутгаас барилгын ажилд хэрэглэгдэх түгээмэл тархацтай ашигт малтмал болон бусад барилгын материалыг авч ашигласан тохиолдолд зохих төлбөр хураамжийг төлөх

- Барилгын ажлын явцад гарсан хог хаягдлыг зөөвөрлөн, төвлөрсөн хогийн цэгт хаяна. Ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.

- Ажлын графикт чанарын хяналтын хугацааг тооцож ирүүлэх бөгөөд хугацааг мөрдөж ажиллана.
- Ажлыг гэрээ байгуулснаас хойш хуанлийн 7 хоногт эхлүүлээгүй тохиолдолд гэрээ цуцлах үндэслэл болно.
- Ажилд тушаалаар томилогдсон мэргэжлийн талбайн инженерийг тогтмол ажиллуулах, мэргэжил шаардсан ажилд мэргэжлийн үнэмлэхтэй ажилчдыг ажиллуулах.
- Үнийн санал ирүүлэхдээ төсвийг ЗТБХБСайдын 2012 оны 181 дүгээр тушаал, Барилгын төсөв зохиох заавар, БНБД81-95-12-г мөрдлөг болгох бөгөөд шууд, нэмэгдэл, ашиг, зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардал, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажил зэргийг тооцож ирүүлнэ.
- Автотээврийн зардлыг ЗТАЖЯ-ны сайдын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 136 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно. ЗТБХБ-ын сайдын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг БД81-112-11 /Барилгын машин ашиглалтын нэг машин-цагийн жишиг үнэ/-ийн дагуу тооцож ирүүлнэ.
- Гүйцэтгэгч нь ажил хийгдэх талбайн гадна иргэд, олон нийтэд зориулсан тухайн бүтээн байгуулалтыг танилцуулах 2*4-оос багагүй хэмжээний самбарыг байршуулж, хамгаалалтын зурвас байгуулна.
- Ажил дууссаны дараа гүйцэтгэлийн зургийг гаргаж, захиалагч болон хяналтын байгууллагад ирүүлнэ.
- Талбайн тохижилтын ажлыг 1 сарын хугацаанд гүйцэтгэнэ.
- Техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох, “Зөрчлийн тухай” хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авах эрхтэй болно.

2. Ажилд хэрэглэгдэх барилгын материалд тавигдах шаардлага

Ашиглаж буй материалууд нь чанарын хувьд олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байх. /БНБД стандартад нийцсэн байна./

- Барилгын материалууд нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан байна.
- Материал нь шинэ, өмнө ашиглагдаагүй, сүүлийн үеийн дэвшилтэт технологи, хандлагыг бүрэн хангасан байна. Мөн Монгол улсын Засгийн газрын 2015 оны “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад орсон материалыг заавал авч ашиглах бөгөөд тайланг гүйцэтгэлд тусгаж ирүүлнэ.
- Ажилд хэрэглэх, элс, айрга, цемент зэрэг түүхий эд материал чанарын шаардлага стандартад нийцсэн байна.
- Дараах түүхий эд материал нь чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан байх ба итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн чанарын шинжилгээний бичигтэй байх
Үүнд: Цемент, бродюр, явган замын хавтан, чулуун хавтан, бусад материалууд
- *Шаардлага хангасан тухай шинжилгээний бичиггүй түүхий эд, материалыг тохижилтын ажилд хэрэглүүлэхгүй болно.*

3. Гэрэлтүүлэг, гадна цахилгааны ажилд тавигдах шаардлага

- Сумын төв талбайн гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн ажлыг хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөл, “Хот тосгон ба, суурин газрын гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх” БД30-102-11, “Цахилгаан техникийн ажил” БНБД3.05.06-90, “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД43-101-03 барилгын норм,

цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, цахилгааны тоног төхөөрөмж ашиглалтын үед мөрдөх дүрмүүдийн дагуу хийж гүйцэтгэх ба ажлын зураг төсвийг баримтлан гүйцэтгэх шаардлагатай.

- Цахилгааны тэжээлийг ОХУ-д үйлдвэрлэсэн ПВ маркийн утсыг пластмассан хоолойд сүвлэн хөрснөөс доошоо, -0.20 түвшинд явуулна.
- Гэрэлтүүлгийн шон /газраас дээш/ 3.5 метр, газарт 1 метрээс багагүй гүнд суулгана.
- Шонг газарт суулгахдаа суурийг цутгаж, зориулалтын анкер боолтоор боож бэхэлнэ.
- Гэрэлтүүлгийн өнгө үзэмж, загвар хийцийг, урьдчилан фото зураг, гарал үүслийн гэрчилгээнд үндэслэн захиалагчтай зөвшилцөж нийлүүлнэ.
- Гэрэлтүүлгийн шон хоорондын зайг зургийн дагуу буюу гэрлийн тусгал жигд тусахаар талбай дээрх зай хэмжээнд тохируулан байршуулна.
- Гэрэлтүүлэгч нь 50 Вт-с доошгүй хүчин чадалтай хурц гэрэлтүүлэмж бүхий диодтой цагаан өнгийн лед гэрэлтүүлэгч байна.
- Гэрэлтүүлэг автоматаар удирдах боломжтой байх бөгөөд удирдлагын самбарт асааж унтраах цагийн тохируулгатай цагийн релей суурилуулна.
- Ажил хийгдсэний дараа далдлагдсан ажлын гүйцэтгэлийн схем зургийг гаргаж, ажил хүлээлгэн өгөхөд захиалагч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

4. Талбай, явган зам, зогсоолын ажилд тавигдах шаардлага

- Талбай, явган зам, зогсоолын ажлыг Хот тосгоны төвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД30.01.04, “Явган зам, талбайн хавтан техникийн шаардлага” MNS 4699:99, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох гарах гарцыг MNS 5682:2006-г тус тус мөрдөх
- Өргөсгөх талбайн ургамлын хөрсийг хуулж тэгшилнэ. Явган зам бүхий талбайд $b=0.10\text{м}$ элсэн дэвсгэр дэвсэж, зориулалтын нягтруулагчаар нягтруулна. */Хөрсний нягтаршлыг заавал шалгуулсны дараа дараагийн үе шатны ажлыг эхлүүлнэ./*
- Чулуун хавтан, явган замын хавтангийн сонголтыг захиалагчтай тохиролцон зурагт заасны дагуу хээний байгуулалтаар хийж гүйцэтгэнэ.
- Явган замын өнгөт хавтангийн үйлдвэрлэгчийн катологи болон хавтангийн дээжийг ирүүлж, захиалагчтай зөвшилцөх
- Явган замын усны уналтыг газар дээр нь тохируулан гаргах
- Явган замын өнгөт хавтангийн зузаан 5 см

5. Сандал, цэцгийн мандал, талбайн ажилд тавигдах шаардлага

- Төв талбайд одоо байгаа гэрлийн цамхагт цаг байрлуулж, 3 өнгийн гэрэл суурилуулна.
- Талбайн баруун, зүүн хэсэгт модон сүүдрэвч хийж байрлуулна. */зургаас үзэх/*
- Талбайг явган замын шар, улбар шар өнгийн хавтангаар өнгөлнө.
- Талбайн зүүн хэсэгт байрлах задгай тайзны хэсэгт 5000/12000мм хэмжээтэй 250мм тоосгон өрлөгтэй WPC шалтай, хойд талдаа 2ш баганатай хийнэ.
- Одоо байгаа зүлэгний хашлагыг 20см-ээр өндөрлөж, өнгөт чулуу наана.
- Талбайн бордюрын хэмжээ: урт-1000, өргөн-80, өндөр-200
- Хашлаганы хашааг модон шонтой олсон хашаагаар хийж гүйцэтгэнэ. */шонгийн өндөр 500мм/*

- Тохижилтын хэсэг болох хогийн сав, сандал ба чулуун хавтангаар өнгөлсөн хашлагатай цэцгийн мандалыг зургийн дагуу байрлуулан цэвэр үзэмжтэй технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Цамхагтай цаг			
1	Цамхагтай цаг /3 өнгийн гэрэл угсрах/	ширхэг	3
Сүүдрэвчийн ажил-2ш			
1	Сүүдрэвчийн бетон суурь цутгах	м3	2.56
2	Модон сүүдрэвч сараалжин хэлбэрээр барих	м2	48
3	Модон сүүдрэвчний хана өнгийн тосон будгаар механизмаар ердийн будах	м2	40
Задгай саравчны ажил			
1	2-р зэргийн хөрсөнд баганын суурь гараар ухах	м3	1.53
2	Баганаан суурийг бетоноор чигжих	м3	1.53
3	Тэгш өнцөгт багана арматурчлаж өрөх	м3	0.96
4	Задгай саравчны бетон шугаман суурь цутгах м100	м	5.28
5	Ердийн тоосгоор энгийн гоёлтой 250мм-ийн тоосгон хана цемент шохойн зуурмагаар гагнаж өрөх	м3	16.5
6	Багана ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	141.6
7	Гадна хана усан эмульсэн будгаар механик аргаар будах	м2	141.6
8	WPC шал хийх	м2	60
Хогийн сав			
1	Хогийн сав тавих	ш	16
Гэрэлтүүлгийн ажил			
1	Шонгийн нүх гараар ухах	м3	0.54
2	Бетоноор чигжих	м3	0.35
3	Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч угсрах /гоёлын/	ш	22
Сандал			
1	Төмөр хөлтэй модон сандал угсрах	ш	20
2	Модон сандал өнгийн тосон будгаар гар аргаар ердийн будах	м2	32
Гэрэлт хаалга зүлэгний хашлага			
1	Шонгийн нүх гараар ухах	м3	2.16
2	Бетоноор чигжих	м3	1.4
3	Хашлага, хана 250мм-ийн тоосгон хана цемент шохойн зуурмагаар гагнаж өрөх	м3	24
4	Тэгш өнцөгт багана арматурчлаж өрөх /гэрэлт хаалганы/	м3	0.96
5	Багана ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м2	245
6	Гадна хана усан эмульсэн будгаар механик аргаар хашлаганы дээд хэсгийг будах	м2	40
7	Гадна хананы хаяавч /цокол/-ын хананд чулуун хавтан	м2	245

	наах		
8	Модон суудал хийж суулгах	ш	14
9	Модон суудал өнгийн тосон будгаар гар аргаар ердийн будах	м2	33.6
10	Хайсны шон суулгах	ш	320
11	Олсоор хадлага татах	у/м	960
Явган замын ажил			
1	Явган замын хавтан тавих талбайг 90 морины хүчтэй бульдозероор тэгшлэж бэлтгэх	м2	500
2	Рейк шугамаар гараар тэгшлэх 3%	м2	15
3	Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийх	м3	102
4	Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийх /улбар ягаан 900м2/ шар 800м2/	м2	1000
5	Замын хашлага тавих /0.5x0.3x0.15м/	1у/м	150

Боловсруулсан: ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- арилгах** тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч

ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээ
с чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Сумын төв талбайг тохижуулах ажил”- ГСАШГСЗДТГ/201912003
ГЕН 2.1	Ажил нь: Ажлын тоо хэмжээ болон техникийн тодорхойлолтоос бүрдэнэ. Ажлын талбай нь Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 1-р багт байрших сумын төв талбай
ГЕН 3.1	Төслийн менежер нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баасанбат
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулах эрх олгосон өдрөөс Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5 хувь байна.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг 2019.10.15-ны дотор гаргаж өгнө.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [хувь]-иар тооцно.
	Ажлын гүйцэтгэлийн 30 хувийг хийсний дараа 30 хувийн санхүүжилтийг олгоно. Ажлын гүйцэтгэлийн явцад 40 хувийн санхүүжилтийг олгох ба ажил дуусч улсын комисст хүлээлгэн өгсөн актыг үндэслэн үлдэгдэл 30 хувийн санхүүжилтийг олгоно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____төгрөг; 20.... онд: _____төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ___ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ___ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]